***Эрхэм таны энэ өдрийн амар амгаланг айлтгая.***



МББСБХ-ны эрхэм гишvvд, банк бус санхvvгийн vйл ажиллагаа эрхлэгчид, энэ салбарт хvчин зvтгэж ирсэн нийт байгууллагууд та бvхний амрыг эрин мэндчилье.

2018 онд Холбоо нь vндсэн зорилго, чиглэлийнхээ хvрээнд толовлосон ажил болон цаг vеийн тулгамдсан асуудлуудыг амжилттай шийдвэрлэж ажиллажээ.

Гишvvдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах vvднээс холбогдох төрийн захиргааны байгууллагууд болон хуулийн этгээдvvдэд ББСҮА тухай хууль журманд байр сууриа илэрхийлэх, татвартай холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, санхvvгийн технологид шинээр vvсч буй нохцол байдлыг оновчтой шийдэл болгох, шудрага орсолдоонийг дэмжиж ББСБ-уудын хэвийн vйл ажиллагааг доголдуулах арга хэмжээнvvдийг таслан зогсоох гэх мэт ажлуудыг гvйцэтгэж vр дvнтэй ажилласан байна.

Нийт 539 ББСБ-уудад, vvнээс Холбооны 200 гишvvн, мэргэжлийн сургалт, арга хэмжээнvvдийг зохион байгуулж, салбарын холбогдох мэдээллээр тогтмол хангаж ажилсанг дурдахад таатай байна.

ББСБуудын нийт актив 32.5 хувиар осон 1.3 их наяд тогрогт хvрч, чанаргvй зээл 9.6 хувь болж 3.1 хувиар буурч, 1.6 сая харилцагчид бvтээгдэхvvн vйлчилгээгээ хvргэсэн, олон талаараа нийгэм эдийн засагт ондор хувь нэмэр оруулсан санхvvгийн зах зээлд улам хvчирхэг салбар болжээ.

Холбоо цаашид гишvvддээ хvргэх vйлчилгээндээ дvн шинжилгээ хийж, эрхэм зорилгынхоо хvрээнд эрх тэгш хvртээмжтэй vйл ажиллагааг эрхэмлэн ажиллах болно. Харилцагчийн эрэлтэд нийцсэн шинэ бvтээгдэхvvн vйлчилгээ, технологийн шийдлvvд, бичил санхvvгийн хvртээмжийг улам ихээр дээшлvvлэх ажлуудыг гишvvд болон хамтран ажилладаг байгууллагуудтайгаа мэргэжлийн ёс зvйтэй, зов засаглал болон комплаенстайгаар хамтдаа шийдвэрлэх болно.

Бидний vйл ажиллагааг vргэлж дэмжиж, эрч хvч бэлгэлж ирсэн Эрхэм холбооны гишvvд, хамт олон, хамтран ажилладаг байгууллагууддаа чинь сэтгэлийн талархал дэвшvvж ажил vйлс тань амжилт бvтээлээр дvvрэн байхыг хvсэн ероое!

***МББСБХолбооны Ерөнхийлөгч***
***Транскапитал ББСБ гvйцэтгэх захирал З.АЛТАНЗУЛ***